

2017 оны 12 дугаар сар

Хураангуй мэдээлэл:


- Банкуудын нийт зээлийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын байдлаар 13.5 их наяд төгрөг байгаагийн 78.7 хувь нь төгрөгийн зээл байна.
- Тайлант сард шинээр 1.6 их наяд төгрөгийн зээл олгогдсоны 70.1 хувь нь төгрөгөөр олгогдсон зээл байна. Харин 1.5 их наяд төгрөгийн зээл төлөгдөв.
- Нийт зээлийн үлдэгдлийн 6.1 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 8.5 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна. Салбараар нь ангилан авч үзвэл усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын чанаргүй зээл 45.8 хувь, уул уурхай олборлолт 23.5 хувь, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбар 22.3 хувь, боловсруулах үйлдвэр 17.5 хувь, барилгын салбар 10.2 хувьтай байна.
- Нийт хэвийн зээлийн үлдэгдлийн 57.0 хувийг 1-5 жилийн хугацаатай зээл, 22.4 хувийг 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээл, 20.6 хувийг 1 жил хүртэлх хугацаатай зээл бүрдүүлж байна. Харин нийт олгосон зээлийн 46.1 хувь нь 1 жил хүртэл хугацаатай, 45.9 хувь нь 1-5 жил хүртэл хугацаатай, 8.0 хувь нь 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай олгогджээ.
- Нийт зээлийн үлдэгдлийн 50.4 хувийг хувийн хэвшилд, 48.9 хувийг иргэдэд олгосон зээл эзэлж байна.
- Банкуудаас аж ахуйн нэгж болон иргэдэд ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл 2.5 их наяд төгрөг байгаа нь нийт банкны салбарын зээлийн үлдэгдлийн 18.3 хувийг бүрдүүлж байна.
- Банкны салбарын зээлийн үлдэгдлийн 23.8 хувь буюу 3.2 их наяд төгрөг нь орон нутаг дахь банкуудаас олгогдсон бөгөөд 1.3 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.4 хувь нь чанаргүй зээлд ангилагджээ.

Зураг 1. Зээлийн үлдэгдэл




Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар өсч 13 их наяд 511 тэрбум төгрөгт хүрчээ. Харин банкуудаас *Монголын Ипотекийн Корпорацид шилжүүлсэн*¹ багцыг оруулж тооцвол нийт зээлийн үлдэгдэл 16 их наяд 30 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар өсчээ.

Зураг 2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /гол салбараар/



Зээлийн жилийн өсөлтийг гол салбаруудаар нь авч үзвэл уул уурхай, олборлолт 1.9 хувиар, худалдааны салбар 0.8 хувиар, боловсруулах үйлдвэрлэл 0.5 хувиар өмнөх оны мөн үетэй харьцуулахад тус тус өссөн байна. Харин барилгын салбарын зээлийн үлдэгдэл 0.5 хувиар, үл хөдлөх хөрөнгийн зээл¹-ийн үлдэгдэл 0.4 хувиар тус тус буурчээ.

Зураг 3. Зээлийн үлдэгдэл /салбараар/




Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл нийт зээлийн үлдэгдлийн 14.1 хувь нь үл хөдлөх хөрөнгийн², 13.8 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 10.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 9.3 хувь нь барилгын, 7.6 хувь нь уул уурхайн салбарт, 24.1 хувь нь бусад салбаруудад олгосон зээл эзэлж байна. Цалин, тэтгэврийн зээл нийт зээлийн 20.9 хувийг бүрдүүлж байна.

¹ МИК-д шилжүүлсэн 2.51 их наяд төгрөгийн зээл банкны салбарын үзүүлэлтээс хасагдаж, бусад санхүүгийн байгууллагын үзүүлэлтэд тусгагдсан.


² МИК-д шилжүүлсэн орон сууцны ипотекийн зээлийг хассанаар

Зураг 4. Зээлийн үлдэгдэл /Валютаар/



Дийлэнх салбаруудад төгрөгөөр олгосон зээл давамгайлж байна. Харин санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, боловсрол, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, уул уурхай олборлолтын салбаруудад валютын зээл давамгайлж байна.

Зураг 5. Иргэд, хувийн хэвшлийн зээлийн жилийн өсөлт



Нийт зээлийн үлдэгдлийн 50.4 хувийг хувийн хэвшилд, 48.9 хувийг иргэдэд олгосон зээл эзэлж байна.

Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 17.9 хувиар, хувийн хэвшлийн зээл 2.5 хувиар тус тус өссөн байна.

Зураг 6. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл /гол салбараар/



Хувийн хэвшлийн зээлийн үлдэгдлийн 21.9 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, 19.4 хувь нь боловсруулах үйлдвэрт, 17.7 хувь нь барилгын салбарт, 14.5 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт ногдож байна.

Зураг 7. Иргэдийн зээлийн үлдэгдэл / гол салбараар/



Иргэдийн зээлийн үлдэгдлийн 46.7 хувийг орон сууцны ипотекийн зээл /МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар/ бүрдүүлж байна. Цалин, тэтгэврийн зээл 31.0 хувийг, хадгаламж барьцаалсан зээл 4.9 хувийг, автомашины зээл 1.9 хувийг тус тус эзэлжээ.


Олгосон зээл

Зураг 8. Олгосон зээл /гол салбараар/



Тухайн сард олгосон зээлийн 25.5 хувь нь худалдааны салбарт олгосон зээл байгаа бол 14.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 11.6 хувь нь цалин, тэтгэврийн зээл, 10.7 хувь нь барилга, 5.5 хувь нь уул уурхай, 4.7 хувь нь үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт тус тус олгожээ.

Зураг 9. Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Тайлант сард нийт олгосон зээлийн 46.1 хувь нь 1 жил хүртэл хугацаатай, 45.9 хувь нь 1-5 жил хүртэл, 8.0 хувь нь 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай олгогджээ.

- 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай
- 1-5 хүртэл жилийн хугацаатай
- 1 хүртэл жилийн хугацаатай

Зураг 10. Хугацаа хэтэрсэн зээл



Худалдаа, уул уурхай олборлолтын салбарт олгосон хугацаа хэтэрсэн зээлийн ангилал сайжирсан болон зарим салбарын зээл төлөгдсөнөөс банкны салбарын хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас 70.4 тэрбум төгрөг буюу 7.9 хувиар буурав.

Зураг 11. Чанаргүй зээлийн хэмжээ ба өөрчлөлт



Чанаргүй зээлд ангилагдсан зээлээс 35.7 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөнөөр үлдэгдэл өмнөх сараас 0.3 хувиар буурчээ. Харин өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар өссөн байна.


Зураг 12. Эрдэлийн сан болон чанаргүй зээлийн харьцаа

Боловсрол	106.6
Санхүү, даатгал	103.1
Уул уурхай	101.2
Усан хангамж	99.6
Барилга	92.5
Төрийн удирдлага	89.9
ЗЭЭЛИЙН БҮГД ДҮН	88.3
Захиргаа	88.0
Худалдаа	87.4
Цахилгаан хий	86.6
Үл хөдлөх хөрөнгө	85.9
Боловсруулах үйлдвэрлэл	83.8
Бусад	80.6
Байр орон сууц	80.0
Хүний эрүүл мэнд	69.9
Тээвэр агуулах	67.7
Мэргэжлийн шинжлэх ухаан	66.9
Хөдөө аж ахуй	55.4
Мэдээлэл холбоо	54.5

Банкууд чанаргүй зээлээс үүдэж гарах алдагдлаас хэр хамгаалагдсан байгаа эсэхийг тодорхойлдог нөөцийн хүрэлцээний харьцаа (provision coverage ratio)-г салбар бүрээр авч үзвэл гол салбаруудаас уул уурхай, олборлолт, барилгын салбарын зээлийн харьцаа хүрэлцээтэй түвшинд байгаа бол хөдөө аж ахуй, тээвэр агуулахын салбар дахь харьцаа бага байна.


Жижиг дунд үйлвэр эрхлэгчдэд олгосон зээл

Зураг 13. Жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийн хэмжээ /салбараар/



ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 2.5 их наяд төгрөгт хүрчээ. Үүнээс 27.2 хувь буюу 670.9 тэрбум төгрөгийг бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 22.4 хувь буюу 552.7 тэрбум төгрөгийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олгожээ. ЖДҮ-ийн зориулалтаар

Зураг 14. ЖДҮ-ийн чанаргүй зээлийн хувь



олгосон нийт зээлийн 13.9 хувь нь чанаргүй зээлд ангилагдсан байна. Салбараар нь авч үзвэл ЖДҮ-ийн зориулалтаар аж ахуйн нэгжид олгосон зээлийн хувьд үйлчилгээний салбарын чанаргүй зээл 27.4 хувь, барилгын салбарынх 23.8 хувь байна. Иргэдэд олгосон зээлийн үлдэгдлийн барилгын салбарын чанаргүй зээл 15.1 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 14.7 хувь, үйлчилгээний болон хөдөө аж ахуйн салбарууд 14.4 хувьтай байна.

Зураг 15. ЖДҮ-ийн зээлийн хүү, хугацаа




ЖДҮ эрхлэгчдэд олгож буй зээлийн жигнэсэн дундаж хүү болон хугацааг харьцуулахад иргэдэд олгосон зээл 16.5 хувиас 23.5 хувийн хүүтэй, хугацааны хувьд 1.4 жилээс 2.4 жилийн хооронд байгаа бол аж ахуйн нэгжид олгосон зээл 16.2 хувиас 22.2 хувийн хүүтэй, хугацааны хувьд 1.1 жилээс 3.1 жил хүртэл хугацаатай олгогдсон байна.

Орон нутгаарх зээлийн үзүүлэлт


- Орон нутгаарх зээлийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын байдлаар 3.2 их наяд төгрөгт байгаагийн 99.8 хувь нь төгрөгийн зээл байна.
- Тайлант сард шинээр 222.3 тэрбум төгрөгийн зээл олгогдсоны 98.9 хувь нь төгрөгийн зээл байна. Харин 237.7 тэрбум төгрөгийн зээл төлөгдөв.
- Нийт орон нутгаарх зээлийн үлдэгдлийн 1.3 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.4 хувь нь чанаргүй зээлд ангилагджээ.
- Орон нутгаарх нийт хэвийн зээлийн үлдэгдлийн 25.4 хувийг 1 хүртэл жилийн хугацаатай, 55.2 хувийг 1-5 хүртэл жилийн хугацаатай, 19.4 хувийг 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээл бүрдүүлж байна.

Зураг 16. Орон нутгаарх зээлдэгчдийн тоо



Нийт зээлдэгчдийг орон нутгаар нь ангилан авч үзвэл Хөвсгөл аймаг хамгийн их буюу 42113 зээлдэгчидтэй байгаа бол Говь-Сүмбэр аймаг хамгийн бага буюу 8467 зээлдэгчидтэй байна. Тайлант сард орон нутаг дахь банкуудаас 222.3 тэрбум төгрөгийн зээл олгосноос 38.3 хувийг төвийн бүсийн³, 29.7 хувийг хангайн бүс⁴, 19.9 хувийг баруун бүс⁵, 12.1 хувийг зүүн бүс⁶-ийн аймгуудад тус тус ногдож байна. Харин 237.7 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөн байна. Үүнээс төвийн бүсийн аймгуудад 35.3 хувь, хангайн бүсэд 31.3 хувь, баруун бүсэд 20.9 хувь, зүүн бүсэд 12.5 хувь тус тус төлөгджээ.

Зураг 17. Олгосон, төлөгдсөн зээл / орон нутгаар/



³ Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгууд
⁴ Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймгууд
⁵ Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Хөвд аймгууд
⁶ Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгууд

Зураг 18. Зээлийн үлдэгдэл / салбаруудаар/



Зээлийн үлдэгдлийг гол салбараар нь ангилан авч үзвэл 54.9 хувийг цалин, тэтгэврийн зээл, 13.6 хувийг үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны, 5.4 хувийг худалдааны салбарт олгосон зээл эзэлж байна.

